

## Нийгмийн Даатгалын Ерөнхий Хууль

## 2024 оны 1-р сарын 1-нээс үйлчилж эхэлнэ

## Холбоо барих:

## Серги Кобахизде

Евроази хариуцсан Партнер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
sergi.kobakhidze@pwc.com

## Чойжамцын Цэндмаа

Захирал  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
tsendmaa.choijamts@pwc.com

## Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний менежер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

## Батчулууны Амаржаргал

Хуулийн үйлчилгээний менежер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
amarjargal.batchuluun@pwc.com

## Өмгөөллийн

## ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

## ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар  
603 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
Факс : +976 11 322068  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)



## Хураангуй

2023 оны 7-р сарын 7-ны өдөр Монгол Улсын Их Хурал Нийгмийн Даатгалын Ерөнхий Хуулийг ("НДЕХ") баталсан ба тус хууль нь 2024 оны 1-р сарын 1-нээс эхлэн одоогийн Нийгмийн Даатгалын тухай Хуулийг (1994) орлон үйлчлэх юм. Энэхүү хууль нь тэтгэврийн ба нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, нийгмийн даатгалыг нөхөн төлөх, тайлагнах зэргийг зохицуулах зорилготой юм.



## Бизнес хамааралтай голлох өөрчлөлтүүд

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

НДЕХ-ийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн хувьд ялимгүй өөрчлөлт орж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын хувь хэмжээ багасч, ажилгүйдлийн даатгалын хувь хэмжээ ихэссэн байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааран 2.5% хүртэл хувиар ялгавартай тогтооно. Энэ хүрээнд Монгол улсын Засгийн Газраас ажил мэргэжлийн жагсаалтыг холбогдох шимтгэлийн хувь хэмжээтэй хамтад нь батлах юм. Мөн Засгийн Газраас жил бүр эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 4 хувиас багагүй байхаар тогтооно.

Нийгмийн даатгалын төрөл	Одоогийн хууль		НДЕХ	
	Ажил олгогч	Ажилтан	Ажил олгогч	Ажилтан
Тэтгэвэр	8.5	8.5	8.5	8.5
Тэтгэмж	1.0	0.8	1.0	0.8
Эрүүл мэнд	2.0	2.0	2.0	2.0
Ажилгүйдэл	0.2	0.2	0.5	0.2
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин	0.8-2,8	-	0.5, 1.5, 2.5	-
Нийт	12.5-14.5	11.5	12.5-14.5	11.5

## АЛБАН ЖУРМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

НДЕХ-ийн дагуу албан журмын даатгалын хамрах хүрээнд хэд хэдэн өөрчлөлт орсон байна. Эдгээрээс гол өөрчлөлүүдийг дурдвал:

- Тэтгэвэр авагч нь хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх болон адилтгах гэрээний дагуу ажиллаж буй тохиолдолд ажилгүйдлээс бусад бүх нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэгтэй болсон;
- Зэрэгцсэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд үндсэн бус ажлаас олж буй орлогоос зөвхөн тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх болсон;
- Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж буй ажилтан нь одоогийн практикаас ялгаатай нь зөвхөн тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгал төлөх үүрэгтэй болсон.

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН болон ПрайсуотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно. © 2023 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН болон ПрайсуотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-ийг илэрхийлнэ.



## Бизнес хамааралтай голлох өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

### ТӨЛӨӨГҮЙ ЭСВЭЛ ДУТУУ ТӨЛСӨН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛӨХ

НДЕХ нь нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх тохиолдлыг бууруурахаар зорьж байна. Иймд, НДЕХ-иар зөвхөн дараах тохиолдолд л нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхийг зөвшөөрсөн байна:

Ажил олгогч цалин хөлсний сан, адилтгах орлогыг нуусан, хэмжээг нь санаатайгаар бууруулсан

Хууль бусаар ажлаас халагдсан тухай шүүхийн шийдвэр гарсан

Хилс хэргээр мөрдөгдсөн, хорих ял эдэлсэн тухай шүүхийн шийдвэр гарсан

Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн эсвэл заасан хугацаанд төлөөгүй

Сайн дураар даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТАЙЛАГНАХ

НДЕХ-ийн дагуу улсын байцаагч дараах гурван зөрчилд акт тогтоосон бол байгууллагууд тайлан нөхөн гаргах үүрэгтэй. Нийгмийн Даатгалын тухай Хуулиар (1994) нөхөн тайлангийн талаар зохицуулаагүй ч практикт нийгмийн даатгалын байгууллагууд шаардлагатай тохиолдолд нөхөн тайлан гаргахыг шаарддаг байна.

01

Ажил олгогч цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан, хэмжээг нь санаатайгаар бууруулсан, буруу тодорхойлсон;

02

Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн;

03

Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг НДЕХ-д заасан хугацаанд төлөөгүй.

### АЛБАН ЖУРМААР НИЙГМИЙН ДААТГАЛ ТӨЛӨХ БОЛОН ТАЙЛАГНАХ ҮҮРЭГ

НДЕХ-ийн дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй компани, төлөөлөгчийн газар, төлөөний газраас гадна Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын хуулийн этгээд нийгмийн даатгалын шимтгэл төлж тайлагнах үүргийг хүлээж байна.



### ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

НДЕХ-ийг баталснаар нийгмийн даатгалын тогтолцоонд хөөн хэлэлцэх хугацааны ойлголтыг нэвтрүүлсэн байна. Тодруулбал, ерөнхий хөөн хэлэлцэх хугацааг 10 жилээр тогтоосон ба тусгай хөөн хэлэлцэх хугацааг 3-6 жилээр ялгаатайгаар тогтоожээ. Мөн энд хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй тохиолдлууд байгаа гэдгийг дурдах нь зүйтэй.

### МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛ

Нийгмийн Даатгалын тухай Хуулиас (1994) ялгаатай нь НДЕХ нь нийгмийн даатгалын маргаан шийдвэрлэх тогтолцоотой холбоотой сүүлийн үеийн өөрчлөлтийг тусгажээ. 2022 онд хоёр үр шаттай нийгмийн даатгалын маргааныг шийдвэрлэх тогтолцоо бий болсон байна. Ингэснээр нийгмийн даатгалын аливаа маргааныг заавал холбогдох түвшний салбар зөвлөл, дараагаар нь төв зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн тохиолдолд л шүүхэд хандах боломжтой болжээ.



### ШИНЭЭР НЭМЭГДСЭН ЗӨРЧЛҮҮД

НДЕХ батлагдсанаар Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт орж, зарим зөрчлийг шинээр нэмсэн байна. Эдгээрээс заримыг дурдвал:

- Сар, улиралд батлагдсан цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг бүрэн тодорхойлоогүй, түүнд оногдох шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр үнэн зөв суутган тооцоогүй;
- Цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтлөөгүй, тайланг буруу гаргасан.

